



**“БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ ТӨСЛИЙН НЭГЖ” ОНӨТҮГ-ЫН 2018 ОНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2018.12.28

БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ ТӨСЛИЙН НЭГЖ-ОНӨТҮГ-ЫН

2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Нэг. Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүн

1.1 Улсын болон нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа ажлын явц

1.1.1 Мал аж ахуйг эрчимжсэн цогц байдлаар хөгжүүлэн, сүү, махны фермерийн аж ахуйд дэмжлэг үзүүлэх замаар нийслэлийн хүн амын сүү, махны хэрэгцээг дотоодын бүтээгдэхүүнээр хангана.

Саалийн үнээний загвар фермийн үйл ажиллагааг тогтворжуулан Сайн констракшн компанийн мэргэжилтнүүдтэй хамтран цахилгааны гэмтлийг засч, шивх зайлуулах хоолойн шугамыг цэвэрлэж, татуургыг ажиллуулан, байнгын ашиглалтанд оруулсан. Мал нарлагааны талбайн хажуу ханыг хавтангаар хашиж өнгөлсөн. Автомат саалтуурыг туршиж, байнгын ажиллагаанд оруулсан. Нийт 25 үнээ тугалж, шинээр 25 төл хүлээн авсан. Малын аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор малын эмчийн үзлэгт байнга оруулж, шаардлагатай вакцинжуулалтад бүрэн хамруулсан.

Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

1.1.2 Хөдөө аж ахуйн зориулалттай газрын ашиглалтыг сайжруулж, өрхийн тариаланг нэмэгдүүлэн, хөрс, цаг уурын онцлогт тохирсон таримлыг тариалуулж, бүтээгдэхүүний гарцыг нэмэгдүүлнэ.

1.1.2.1 Хөдөө аж ахуйн техникийн хүчин чадлыг нэмэгдүүлж, сургалт үйлдвэрлэлийн бааз бий болгон, үйлдвэр эрхлэгчдийн чадавхийг нэмэгдүүлэх сургалтууд зохион байгуулна.

Бага оврын хөдөө аж ахуйн тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын хүрээнд тоног төхөөрөмжийн судалгаа явуулж, тендерийн баримт бичгийг стандартын дагуу боловсруулан 2 дугаар сард Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлсэн. Уг тендерийн сонгон шалгаруулах ажлын хэсэгт Төслийн менежер орж, бусад гишүүдийн хамт худалдан авах ажиллагааг зохион байгуулсан. Тендерийг 2018 оны 2 дугаар сарын 12-

ны өдөр зарлаж, 3 дугаар сарын 14 - ний өдөр нээсэн боловч нэг ч компани санал ирүүлээгүй тул тендерийг дахин зарлахаар гишүүд шийдвэрлэсэн. Тендерийн дахин сонгон шалгаруулалтын нээлтийн ажиллагаа 4 дүгээр сарын 16 нд болж, хоёр компани санал ирүүлснээс “Глобал бизнес” Линк ХХК шалгарч, 2018 оны 5 дугаар сарын 25 ны өдөр Хүнс, хөдөө аж ахуйн газартай гэрээ байгуулсан. Хөдөө аж ахуйн зориулалт бүхий анжис, хүнд диск, роторт сийрүүлэгч, төмс үрлэгч, төмс хураагч, усалгааны систем, нарийн ногооны үрлэгч, хор цацагч төмсний кон болон 5 тоннын даацтай өргөгч кран зэрэг 10 төрлийн тоног төхөөрөмжүүд графикийн дагуу хугацаандаа нийлүүлэгдсэн. НХХААГ-ын даргын тушаалаар томилогдсон тус газрын хэлтсийн дарга Ц.Төмөртулгаар ахлуулсан хүлээн авах комисс 2018 оны 10 дугаар сарын 02 –ны өдөр талбай дээр ажиллаж, техник тоног төхөөрөмж нэг бүрийг нэг бүрчлэн угсруулан ажиллуулж, акт үйлдэж хүлээн авсан. Мөн Нийслэлийн өмчийн харилцааны газрын 2018 оны 10 дугаар сарын 15 ны өдрийн 2/1582 тоот албан бичгийн дагуу дээрхи техник, тоног төхөөрөмжүүдийг байгууллагын бүртгэлд хүлээн авсан.



ХААИС, Монгол –Копиа төвийн хамтран зохион байгуулсан “Тэжээлийн ургамал тариалах технологи” сургалт, туршлага солилцох уулзалтанд оролцож, байгууллагын танилцуулга, авч хэрэгжүүлж буй ажил, туршилт үйл ажиллагааны талаар тодорхой илтгэл тавьж, сонирхсон асуултад хариулсан.

НХХААГ болон “Нутаг академи” ТББ-тай хамтран “Бод малын зохиомол хээлтүүлгийн техникч бэлтгэх” вакумжуулсан сургалтыг байгууллагын фермийн аж ахуй дээр түшиглэн зохион байгуулсан. Хөдөө орон нутаг болон нийслэлээс сургалтанд хамрагдсан 15 хүнд байгууллагын зүгээс нэвтрүүлж байгаа дэвшилтэт техник,

технологи, төслийн үр дүн, ач холбогдлын талаар талбайн танилцуулах сургалт хийсэн. “Ногоон алмааз-Агро” ТББ-тай хамтран газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх сонирхол бүхий 58 иргэнд дадлага сургалтыг зохион байгуулж, зөвлөгөө өгч, ажилласан.



1.1.2.2 Органик бордооны үйлдвэрлэлийг туршиж, ажлыг эхлүүлнэ.

Малын өтөг бууц нийт 70 тонныг ойр хавийн фермерүүд болон өөрийн фермийн аж ахуйгаас цуглуулан, өвс, хог ургамлын үлдэгдэл, хаягдсан модны мөчир, ногооны хальс, хоол хүнсний үлдэгдэл зэрэг зарим органик хог хаягдал зэрэгтэй хольж, норгох, холих ажлыг технологийн дагуу хийж органик бордоо (компост) бэлтгэсэн. Ирэх жил талбай бордох туршилтын ажлыг явуулахаар төлөвлөж байна.

Фермийн байрны доор байрлах шивх хадгалах нүхэнд үхэр байрласанаас хойш хугацаанд хуримтлагдсан шивхнээс соруулан авч, усаар шингэлж зориулалтын техник ашиглан 6-р сард тариалалт хийхээс өмнө 4 га талбайд цацаж туршилтын ажлыг гүйцэтгэсэн. Шивхээр бордсон талбайн олон наст таримлын ургалтын эрчим нэмэгдэж байсан нь 7, 14 хоног тутамд явуулсан үзэгдэл зүйн үе шатны ажиглалтаар батлагдсан. Азот, фосфор, калийн нийлмэл эрдэс бордоогоор зориулалтын бордоо цацагч машин ашиглан БНАУ-аас нийлүүлсэн олон наст таримлын холимог үрээр тариалалт хийхээс өмнө 20 га газарт бордох ажлыг хийж гүйцэтгэсэн. Хөрсний тэжээлийн бодисын агууламж хэрхэн нэмэгдсэнийг тодорхойлох зорилгоор 4 цэгээс 9

дээж авч 3 дээжийг нь БНАУ-руу, 6 дээжийг МААЭШХ-ийн итгэмжлэгдсэн лабораторт шинжлүүлэхээр өгч албан ёсны хариу хүлээж байна.



Хоёр. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт

Манай байгууллагад тусгайлан заасан тогтоол шийдвэр байхгүй

Гурав. Байгууллагын үйл ажиллагааны үр дүн

3.1 Дүрмээр хүлээсэн үүргийн биелэлт

3.1.1 Бэлчээрийн талбайг хагалахгүй, хөрсний унаган төрхийг алдагдуулахгүйгээр үрлэж тариалах Австри улсын дэвшилтэт шинэ технологийг туршиж, нэвтрүүлэх

Австри улсаас нийлүүлэгдсэн олон наст холимог ургамлын үрийг гаалийн бүрдүүлэлт хийж, хүлээн авч, фермийн аж ахуйн талбайд хүргэсэн. Уг олон наст ургамлын холимог үрийг тариалах арга технологийн дагуу Guettler үрлэгчийг ашиглан 05 дугаар сард 40 га талбайд, 6 дугаар сарын 2 дугаар арав хоногоос эхэлж 40 га талбайд тариалалтын ажлыг гүйцэтгэсэн. Үрийн нормыг 1 га талбайд 15 кг үр орохоор тооцож хийсэн. Тариалалт хийсэн БНАУ-ын 2 төрөл, 8 зүйл, 21 сортын тэжээлийн олон наст үрийн холимог болон Монгол орны нөхцөлд өргөн тариалагддаг 4-5 зүйлийн олон наст ургамлын үрийн холимгийн ургалт, ургац, усалгаа, шим болон эрдэс бордооны

үйлчлэл тооцох харьцуулсан туршилтыг 12 хувилбартай тус бүр 3 давталттайгаар 2500 м² талбайд явуулсан. Энэ жилийн хувьд хур тунадас 7 дугаар сарын 2 дугаар арав хоногоос эхлэн орсон бөгөөд ажиглалт, судалгааны ажлыг тухай бүр хийж тэмдэглэл хөтөлж ажилласан.



Тариалалт хийгдээгүй талбай

Тариалалт хийгдсэн талбай

3.1.2 Дээрхи технологийн дагуу тариалсан олон найрлагат, уурагжуулсан витаминт тэжээлийг вакуумжуулан боох аргыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх,

Тариалалт хийгдсэн олон наст таримлыг эхний жилдээ ямар нэгэн хадалт хийхгүйгээр өвөлжүүлдэг агротехнологийн зарчмыг мөрдөж ажилласан. Харин туршилтын журмаар 15 га талбайгаас 9-р сарын эхээр түүвэрлэсэн хадалт хийж 2 рулон буюу 800 кг ногоон тэжээл, 0,4 тн-оор преселж боосон 3.2 тн өвсөн тэжээл хураан авсан. Ургац хураалтаас өмнө 5-н цэгээс 1 м² талбайгаас 3-н давталттай өвсний дээж авч ерөнхий шинжилгээ хийлгэсэн. Вакуумжуулсан ногоон тэжээл бэлтгэсэн хэсгийнх уургийн агууламж нь 2 % -иар илүү байсан.



3.1.3 Тэжээлийн ургамлын бүтэц, бүрдлийг нэмэгдүүлэх замаар нэгж талбайгаас авах хадлангийн гарцыг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэх,

Мал аж ахуйн Хүрээлэнгийн ургамал судлаач багш нартай хамтран байгууллагын хашаалсан 150 га туршилтын талбайн тариалалт хийгдээгүй 10х10 м² талбайд гурван давталттайгаар ургамлын бичиглэлийг 2018 оны 06 дугаар сарын 14-ний өдөр гүйцэтгэсэн. Нийт тариалалт хийсэн 80 га талбайн 70 %-д олон наст таримлын ургалт 8-15 см, 20 %-д 20-30 см орчим өндөртэй байлаа. Хоёр зүйлийн буурцагтан болох Мөлхөө хошоонгор Царгасаас царгас нь ургасан, 6-н зүйлийн үетэнээс *Dactylis glomerata*, *Lolium perenne*, Олон наст риэгрэс, Нугын дурваалиг, Улаан ботууль ургасан. Нугын биелэг өвсний ургалт муу, *Хуурамч овъёос* нэртэй үетэн ургамал огт ургаагүй нь ажиглагдсан.


3.1.4 Нэгж талбайгаас авах хадлангийн хэмжээ болон ногоон тэжээлийн чанарыг дээшлүүлснээр саалийн хугацаанд авах сүүний хэмжээг нэмэгдүүлэх,

Тариалалт хийсэн нийт талбайн хэмжээгээр авч үзвэл ургалтын эрчим олон наст ургамлын үрийн тариалалтын эхний жил учир харьцангуй бага гарсан тул ногоон

тэжээлийн хэмжээ нэмэгдээгүй. Дараа жилээс ногоон тэжээлийн хэмжээ эрс нэмэгдэж, сүүний гарцыг нэмэгдүүлэх боломж бүрдэнэ.

3.1.5 Сургалтын төв, дадлагын талбай болон засварын төв бүхий “Эрчимжсэн мал аж ахуйн загвар аж ахуй” байгуулах

Саалийн үнээний загвар фермийн үйл ажиллагааг тогтворжуулан Сайн констракшн компанийн мэргэжилтнүүдтэй хамтран цахилгааны гэмтлийг засч, шивх зайлуулах хоолойн шугамыг цэвэрлэж, татуургыг ажиллуулан, байнгын ашиглалтанд оруулсан. Мал нарлагааны талбайн хажуу ханыг хавтангаар хашиж өнгөлсөн. Техник тоног төхөөрөмжийн гараж болон сургалтын төвийн байрыг улсын комисс хүлээн авахад болсон. Мөн үнээний автомат саалтуурыг туршиж, байнгын ажиллагаанд оруулсан.



3.2 Хүний нөөцийг чадавхижуулах

НЗДТГазарын Санхүү төрийн сангийн хэлтэсээс төсвийн ерөнхийлөн захирагч нар болон нягтлан бодогч нарын дунд зохион байгуулсан 2 удаагийн семинарт оролцсон. Гадаад албан томилолтын хүрээнд БНСУ-ын Пусан хоттой ах дүүгийн хамтын ажиллагааны харилцаатай 6 орны төлөөлөгчид хамрагдсан сургалтанд төслийн менежер Г.Пүрэвсүрэн Нийслэлийн хөдөө аж ахуйн салбарын талаар илтгэл тавьж, амжилттай оролцсон. Байгууллагын дарга Г.Галдөл Санхүү эдийн засгийн дээд сургуулийг МБА хөтөлбөрт сурч амжилттай төгссөн. “Тэжээлийн ургамал тариалах технологи” сэдэвт сургалтанд агрономч Б.Баярцэцэг оролцож, байгууллагын үндсэн

үйл ажиллагааны талаар илтгэл тавьсан. Нийслэлийн Өмчийн харилцааны газраас зохион байгуулсан 2 удаагийн сургалтанд нягтлан бодогч Ц.Мөнхдөл хамрагдсан. Хүний нөөц, бичиг хэргийн мэргэжилтэн Отгонтэнгэр Их сургуульд хууль, эрх зүйн чиглэлээр сурч байна.

3.3 Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын талаар

Тайлангийн хугацаанд иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдол байхгүй болно.

Дөрөв. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
Нэг. Үйл ажиллагааны ил тод байдал			
1	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Байгууллагын веб сайт, мэдээллийн самбарыг тогтмол ажиллуулж, холбогдох мэдээллийг байршуулан ажилласан.	
2	Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Хүний нөөцийн мэргэжилтэн А.Гэрэлтуяа хариуцан, иргэдтэй уулзах цагийн хуваарийг мэдээллийн самбартаа байрлуулж ажилладаг.	
3	Үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Шинээр нийлүүлэгдсэн техник тоног төхөөрөмжүүдийг ашиглан хамтран ажиллах хүсэлт тавьсан аж ахуйн нэг газар тариалангийн үйлчилгээг төлбөртэйгээр хийж гүйцэтгэх талаар мэдээллийн самбар, байгууллагын брошур, танилцуулга дээр байршуулан ажилласан.	
4	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа байрлуулж, тухай бүр нь шинэчилдэг.	
5	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон захиргааны хэм хэмжээний актын шийдвэрийн төслийг цахим хуудсандаа 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулж, холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч,	Байгууллагын дотоод журмыг шинэчлэн боловсруулж цахим хуудсандаа байршуулан ажилласан.	

	эрдэмтэн, иргэдийн саналыг авах, үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгах;		
6	Үзүүлж байгаа үйлчилгээний арга, хэлбэрийг боловсронгуй болгох зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;	Байгууллагын танилцуулгыг шинэчлэн боловсруулж брошур хэлбэрээр хэвлэж СХД-ийн 21 дүгээр хорооны Нарийний амны иргэд болон шинэ суурьшлын бүсэд шилжин суурьшсан малчдад танилцуулж, хамтран ажилласан.	
7	Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн байгууллагын гүйцэтгэх тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага гүйцэтгэж байгаа тохиолдолд тухайн төрийн бус байгууллагын нэр, хаяг, цахим хуудас, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлэх;	-	
8	Тухайн байгууллага тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эсхүл бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодог бол тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	-	
9	Салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, байдлын талаарх мэдээллийг цахим хуудсандаа байрлуулан тухай бүр шинэчлэх;	Хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үйл ажиллагааны талаархи мэдээллийг цахим хуудсандаа байрлуулан ажиллаж байна.	
Хэсгийн дундаж хувь:			
Хоёр. Хүний нөөцийн ил тод байдал;			
1	Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах;	Сул орон тооны зарыг мэдээллийн самбартаа байрлуулж, ХААИС гэх мэт мэргэжлийн байгууллагад хүний нөөцийн талаар санал тавьж, ажилласан.	
2	Албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Албан хаагчийн Ёс зүйн дүрмийг шинэчлэн баталж, мэдээллийн самбарт байрлуулан ажилласан.	
3	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх;	Байгууллагын дотоод журам, ур чадварын нэмэгдэл олгох журам болон ур чадварын гүйцэтгэл олгох шалгуур үзүүлэлтүүдийг байгууллагын веб сайтанд байршуулан ажилласан.	

4	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх;	Ажлын үр дүнгийн шагнал урамшуулал олгох, Ур чадварын нэмэгдэл олгох журмыг боловсруулан даргын тушаалаар батлуулсаны дагуу дүгнэж, байгууллагын мэдээллийн самбарт байрлуулан ажиллаж байна.	
Хэсгийн дундаж хувь:			

Тав. Бусад

5.1 Бэлчээрийн менежемент төслийн ач холбогдол, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар СХД-ийн 21 дүгээр хорооны Нарийний амны иргэд болон мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсээс шинэ суурьшлын бүсэд шилжиж суурьшсан малчидад танилцуулга хийж, цаашид хамтран ажиллах боломжийн талаар судалгаа явуулсан.

5.2 Аж ахуйн үйл ажиллагаа явуулж, нэмэлтээр орлого олох, дараа жилүүдэд тариалалт хийх цэвэр сортын төмсний үртэй болох зорилгоор 1.0 га талбайд хагалгаа, боловсруулалт хийж 3000 кг “Гала” сортын төмсний элит үрээр тариалалт хийж, нийт 9000 кг төмс хураан авсан.

5.3 Төслийн хүрээнд нийлүүлэгдсэн техник, тоног төхөөрөмжүүдийн засвар үйлчилгээг тогтмол хийж, байнгын бэлэн байдлыг ханган, иргэн, аж ахуйн нэгжийн захиалгын дагуу зориулалтын техник ашиглан нийт 10 га талбайд боловсруулалт хийж, 34 га талбайд өтөг бууц цацаж, 12 га талбайд овъёос хадаж, тармаж, пресслэх ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэсэн.

ТАЙЛАН НЭГТГЭСЭН: МЕНЕЖЕР
ТАНИЛЦАЖ ЗӨВШӨӨРСӨН: ДАРГА

/Г.ПҮРЭВСҮРЭН/
/Г.ГАЛДӨЛ/